



ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 20 өдөр

Дугаар 4/39

Хэрлэн сум

Нууц баримт бичигт үзлэг  
явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам”-ын 12.1, 12.2, 12.4, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 213 дугаар зарлиг, “Монгол Улсын Батлан хамгаалахын төрийн болон албаны нууцыг хамгаалах журам”-ын 20 дугаар бүлгийн 20.1, 20.2, 20.3, 20.4, 20.5, 20.6, 20.7 дэх, заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Улсын дайчилгаа хариуцсан ажилтны хариуцаж буй нууц баримт бичигт үзлэг явуулж, шалган туслах ажлыг 2022 оны 6 дугаар сарын 20-оос 2022 оны 6 дугаар сарын 21-ний өдрүүдэд явуулсугай.

2. Тооллогын комиссыг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Тооллогын комиссын

дарга: Н.Хүрэлээ Цэргийн штабын дарга Хурандаа

Гишүүд: Л.Цэнддорж Цэргийн штабын Дайчилгааны  
офицер хошууч

А.Баярбат Цэргийн штабын Тоо бүртгэлийн  
офицер хошууч

3. Улсын дайчилгаа хариуцсан ажилтны нууц баримт бичигт үзлэг шалгалтыг заасан хугацаанд чанартай явуулж материалыг Батлан хамгаалах яамы Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Орон нутгийн хамгаалалт, улсын дайчилгааны хэлтэст хүргүүлж, 2022 оны 7 дугаар сарын 01-д илтгэхийг тооллогын комисс (Н.Хүрэлээ)-т даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР